



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 27 өдөр

Дугаар A/33

Шивээговь сум

Өндөржүүлсэн бэлэн байдлын үед авч  
хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.в, 29.1.6.а, б, л, 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.8, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1, 11.2.3, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 10 дугаар зарлиг, Засгийн газрын 2020 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 62 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 06 дугаар хуралдааны шийдвэр, аймгийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн A/64 дүгээр захирамж, сумын Онцгой комиссын 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 05 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн  
**ЗАХИРАМЖЛАХ НЬ:**

1. Сумын төвөөс орох, гарах хөдөлгөөнийг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 08:00 цагаас үргэлжлүүлэн 03 дугаар сарын 03-ны өдрийн 08:00 цаг хүртэлх хугацаанд хязгаарласугай.
2. Хяналтын цэгийн байршил, ажиллах хуваарийг хавсралт ёсоор баталсугай.
3. Хяналтын цэгт ажиллах ажлын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, хэрэгжүүлэн ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, онцгой комиссын орлогч дарга /Б.Баасанбат/-д үүрэг болгосугай.
4. Хяналтын цэгт ажиллаж байгаа ажилтнуудын аюулгүй байдлыг хангаж, эм зүйн хэрэгсэл, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, хэрэгсэл, ариутгал халдвартгүйтгэлийн бодис, амны хаалтаар хангаж ажиллахыг байгууллагын дарга, захирал, эрхлэгч, онцгой комиссын гишүүдэд, иргэдэд мэдээлэл, ухуулга

сурталчилгаа хийхийг Соёлын төвийн эрхлэгч, онцгой комиссын гишүүн /Э.Төрмандах/-д, ариутгал халдвартгүйтгэл хийхийг Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч, онцгой комиссын гишүүн /Ш.Буяннэмэх/-д, сумын хүнсний бүтээгдэхүүний хангалтыг хариуцаж ажиллахыг Санхүүгийн албаны дарга, онцгой комиссын гишүүн /У.Чулзуунцэцэг/ нарт тус тус даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч, Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн дарга /Ж.Батмөнх/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЯГААНЦЭЦЭГ

Сумын Засаг даргын ... оны ...-р  
сарын ...-ны өдрийн ... дугаар  
захирамжийн хавсралт



### ХЯНАЛТЫН ЦЭГИЙН БАЙРШИЛ

№	Хяналтын цэгийн дугаар	Байршил	Жижүүрлэх албан хаагчид
1.	I	Төв зам	1. Цагдаагийн хэсгийн хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч Б.Зориг-Эрдэнэ 2. Цагдаагийн хэсгийн зохицуулагч, цагдаагийн ахлах дэслэгч Д.Өнөржаргал 3. Цагдаагийн хэсгийн жижүүрийн цагдаа, сургач, ахлагч Ш.Батмөнх 4. ЗДТГ 5. ИШОНӨҮГ 6. ЕБСургууль 7. Соёлын төв
2.	II	Сумын төвийн урд хэсэг	1. Цагдаагийн хэсгийн цагдаа, жолооч М.Анх-Эрдэнэ 2. Цагдаагийн хэсгийн жижүүрийн цагдаа, дэд ахлагч Г.Ууганбаатар 3. Ерөнхий боловсролын сургууль 4. ЗДТГ 5. ИТХ 6. ЕБСургууль
3.	III	Уурхай, 21-р зөрлөгийн нүхэн гарц	ШОХК

### ХЯНАЛТЫН ЦЭГҮҮДЭД ХЯНАЛТ ТАВИХ ХУВААРЬ

№	Хяналт тавих албан хаагчийн овог нэр, албан тушаал	Хяналтаар явах сар, өдөр
1.	Сумын Засаг даргын орлогч Ж.Батмөнх, Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч Ц.Баасанжав	II/27
2.	ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Баасанбат, Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч Ц.Баасанжав	II/28
3.	ИШОНӨҮГ-ын захирал Ү.Даваасүрэн, Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч Ц.Баасанжав	II/29
4.	ЗДТГ-ын Санхүүгийн албаны дарга У.Чулуунцэцэг, Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч Ц.Баасанжав	III/1
5.	Ерөнхий боловсролын сургуулийн захирал Д.Буяндэлгэр, Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч Ц.Баасанжав	III/2